

Авлигаас урьдчилан
сэргийлэх ажиллагаанд
олон нийтийн оролцоог
хангах нь

2017 он

Оршил

- ▶ Олон нийт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдэлснээр аливаа шийдвэр гаргах ажиллагаанд бодитой нөлөө үзүүлж, шийдвэрийг хэрэгжүүлэх иргэдийн ухамсар, идэвх санаачлага нэмэгддэг байна.
- ▶ Иймд аливаа урьдчилан сэргийлэх ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаснаараа ямар ач холбогдолтой болох талаар ойлголт өгөх зорилгоор мэдээллийн бэлтгэв.



Агуулга

Ойлголт

Эрх зүйн зохицуулалт

Арга, хэлбэр

Үр дүнтэй алхам, ололт амжилт

Олон нийтийн оролцоог хангах боломжууд.



Ойлголт

Урьдчилан сэргийлэх

Олон нийт

Оролцоо

- шалтгаан, нөхцөлийг
судлан тогтоох,
- арилгах,
- таслан зогсооход
чиглэгдсэн арга
хэмжээний цогцолбор

нийгмийн нэг хэсгийг
тодорхойлсон ойлголт

аливаа асуудлыг шийдэх
вйл хэрэгт өөрийн биеэр
оролцохыг

Эрх зүйн зохицуулалт

Авлигын эсрэг конвенци



- Нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, түүн дэх олон нийтийн оролцоог дэмжих, олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах, авлигыг үл тэвчих уур амьсгал бий болгоход хувь нэмэр оруулахад чиглэсэн олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа, дунд болон их, дээд сургуулийн хөтөлбөр зэрэг олон нийтийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, авлигатай холбоотой мэдээлэл эрэх, авах, хэвлэн нийтлэх, тараах эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих, хамгаалах арга хэмжээ авахаар

Авлигын эсрэг хууль



- 5 дугаар зүйлийн 5.1.1-д “шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах”,
- 6 дугаар зүйлийн 6.1.2-д “тодорхой чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх”

ТБОНӨХБАУХАТХ



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд Худалдан авах ажиллагаан дахь олон нийтийн оролцоо хангах зүйлийг

Эрх зүйн зохицуулалт

Төсвийн тухай хууль



- төсвийн ил тод байдлыг хангах зарчмын хүрээнд олон нийтийн хяналт тавих

Захирганы Ерөнхий хууль



- хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д “”бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах” гэж олон нийтийг мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлээд байна.

Хууль тогтоогмжийн тухай хууль



- “хууль тогтоомжийг санаачлан боловсруулах, олон нийтийн оролцоог хангах, эрх зүйн дүгнэлт хийх, өргөн мэдүүлэх, батлагдсан хууль тогтоомжийг хэвлэн нийтлэх, олон нийтэд таниулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах

Эрх зүйн зохицуулалт



Нийтийн сонголын тухай хууль

- хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлаар шийдвэр гаргахын өмнө төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн шинжээчээс санал сонсож мэдээлэл авах нийтийн сонголыг зохион байгуулж төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангах



Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай

- төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай



Шилэн дансны тухай хууль

- төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэх

Оролцоог хангах хэлбэр

- ▶ жагсаал хийх, эсэргүүцлийн цуглаан зохион байгуулах, сонин хэвлэлийн эзэд, улс төрчдөд хандан захидал илгээлт явуулах, ухуулах хуудас, товхимол хэвлүүлэх, хэвлэл мэдээллээр дамжуулан мэдээлэл түгээх
- ▶ судалгаа авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, цахим хэлбэрээр



Оролцоог бий болгоход



Оролцоог хангахад



Төрийн байгууллага олон нийтийн оролцоог хангах

аливаа мэдээллийг
ил тод болгох

сонирхогч этгээдийн
санал бодлоо
илэрхийлэх нөхцөл
бололцоог
бүрдүүлэх

гарсан саналыг
шийдвэртээ тусгах

Төрийн байгууллага

бодлого боловсруулах, шийдвэр гаргахын өмнө олон нийтийн анхаарал татаж байгаа мэдээллийг нээлттэй болгох, сонирхогч нийгмийн бүлгүүдэд өөрийн бодлого, байр суурийг танилцуулах, хяналтын тодорхой аргыг дэвшүүлэн хэрэгжүүлэх бололцоо олгох зорилгоор харилцан зөвлөлдөж ажиллах боломжийг бүрдүүлэх;

төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах;

төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх;

чиг үүргийн дагуу зөвшөөрөл, эрх олгох, бүртгэл хийх, хяналт тавих, сонгон шалгаруулалт явуулах зэрэг асуудлыг шийдвэрлэх журмыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол олон нийтэд ил тод байлгаж, түүнтэй танилцах боломжоор хангах;

ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг хууль, тогтоомжид заасны дагуу тогтоон мөрдүүлэх;

нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх;

авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх асуудлыг бүтцийн нэгждээ хариуцуулах;

төрийн байгууллага тухайн салбарын албан хаагчийн ёс зүйн дүрмийг батлан гаргахын өмнө Авлигатай тэмцэх газраас санал авах;

төрийн байгууллагаас гаргасан шийдвэр иргэд болон бусад сонирхогч талуудад ойлгомжтой, нээлттэй байх;

иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх;

бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаварыг нь арилгах арга хэмжээ авах;

авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих нийтлэг үүрэг хүлээлгэсэн байдаг юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан нийтлэг үүрэг;

Авлигатай тэмцэх газар урьдчилан сэргийлэх чиглэлээр

авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэнд нь хяналт тавих

авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах талаар аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зөвлөлд үүрэг, чиглэл өгөх

авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх


төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах

авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх

авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх

төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх

Шилэн дансны нэгдсэн цахим хуудас



- ▶ 522,390 хандалтаар
- ▶ 495,342 мэдээллийг
- ▶ 422,471 хэрэглэгч
- ▶ 426,085 удаагийн хандалтаар
- ▶ 2 сая мэдээллийг хүлээн авсан

Цаашид хэрэгжүүлэх арга замууд

- ▶ Монгол Улсын их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.
- ▶ Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсын нэрийг олон улсын төвшинд гаргах үндэсний хэмжээний баримт бичиг юм.
- ▶ 2 үе шаттайгаар
- ▶ 6 жилийн хугацаатай

Хөтөлбөр хэрэгжсэнээр

төрийн
байгууллагад
итгэх иргэний
итгэл нэмэгдсэн

авлигатай
тэмцэх үйл
ажиллагаанд
олон нийтийн
оролцоо,
хяналт
сайжирсан

төрийн
үйлчилгээний
ил тод,
нээлттэй
байдал
хангагдсан

төрийн
үйлчилгээг
цахим
хэлбэрт
шилжүүлсэн

төрийн
байгууллагын
шударга
байдлын
үнэлгээ
сайжирсан

“Иргэд, олон нийт, иргэний нийгмийн байгууллагын
идэвх санаачилга, оролцоог дэмжих”



ИНБ



Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангах зорилгоор




- ▶ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын Дэд зөвлөл

▶ 156



Авлигын улмаас учирсан эдийн засгийн хохирлыг төлүүлэхэд



- ▶ авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалгахад мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудын туслалцааг авах

Анхаарал хандуулсанд
баярлалаа

